

Бусдыг Есүс Христ рүү хөтлөх нь

Дараах нөхцөлүүдээс нэгийг сонгоно уу.

- Тантай найзалдаг нэгэн залуу эрэгтэй Христийн өөр сүмд харьяалагддаг. Нэг өдөр үдийн цайны үеэр та тэр залуу эрэгтэйтэй Сүмийн талаар ярихаар сүнслэгээр өдөөгдсөн.
- Та сургуулиас гэр рүүгээ алхаж байхдаа уйлж байгаа нэгэн залуу эмэгтэйг харсан. Та түүнийг нэлээд хэдэн жил Сүмийн ямар ч цуглаанд ирээгүй, тойргийнх нь нэг гишүүн болохыг таньсан. Та түүнтэй ярих хэрэгтэй гэж мэдэрсэн. Таныг түүнийг тайвшруулахаар хичээж байхад тэр өөрт тохиолдсон бэрхшээлээ дүрслээд, “Би яагаад зүгээр л аз жаргалтай байж болохгүй гэж?” хэмээн асуусан.
- Олон нийтийн мэдээллийн сайтад тантай холбоотой байдаг нэгэн залуугийн ээж саяхан нас баржээ. Түүний саяхны тавьсан “Яг одоо маш их ганцаардаж байна. Хэн нэгэн ойлгоосой гэж хүсэж байна” гэсэн сэтгэгдэлд хариулах мэдрэмж танд төрсөн.

Энэ хуудас цаасны ард эсвэл хичээлийн дэвтэр юм уу судрын тэмдэглэлдээ энэ хүнийг Есүс Христ рүү хөтлөхөд туслах юуг хэлж мөн хийхээ бич. Тайлбартаа дараах асуултуудад хариулж бич.

- Та энэ хүнийг Есүс Христ рүү хөтлөхөд туслах сайн мэдээний ямар үнэнийг хуваалцах вэ?
- Энэ хүнийг суралцуулахаар таны урьж болох судар юу вэ?
- Та энэ хүнийг юу хийхэд урих вэ?

